



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 09 өдөр

Дугаар А/293

Мөрөн сум

Захирамжид өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мөрөн сумын Засаг даргын санал, иргэн Баярмагнай овогтой Түмэн-Өлзий /РЭ88121431/-ийн хүсэлтийг тус тус үндэслэн аймгийн Засаг даргын 2021 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн А/360 дугаар захирамжийн хавсралтын 2 дахь заалтаар Мөрөн 8 дугаар баг 8-616 тоотод байршилтай 6712016736 нэгж талбарын дугаартай 1862м² гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрын зориулалтыг үйлчилгээтэй орон сууцны зориулалт бүхий болгон өөрчилж үлдсэн 27 жилийн хугацаагаар үргэлжлүүлэн эзэмшүүлсүгэй.


2. Уг захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2021 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн А/360 дугаар захирамжийн хавсралтын 2 дахь заалтын 5 дахь баганыг хүчингүй болгосугай.

3. Уг захирамжаар газар эзэмшиж байгаа Б.Түмэн-Өлзий /РЭ88121431/-тэй газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг), Улсын бүртгэлийн хэлтэс (Б.Мөнгөнзул) нарт тус тус зөвшөөрсүгэй.

4. Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг)-т үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (М.Алтаншагай), Мэргэжлийн хяналтын газар (Д.Түмэнбаяр) нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН